

Инно хими лаб ХХК



ИННО ХИМИ ЛАБ ХХК

МЭДЭЭЛЛИЙН НЭР:

**ЕВРОПЫН ХОЛБООНЫ
СЭРЭМЖЛҮҮЛЭГ, ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ СҮЛЖЭЭНИЙ 2023
ОНЫ ТАЙЛАНГИЙН АЛБАН БУС
ОРЧУУЛГА**

Утас: 77051414
И-мэйл: info@innocchem.mn
Вэбсайт: www.medimpex.mn
Фэйсбүүк:
Инно лаборатори
Agilent Demo Center

Мэдээллийн эх сурвалж: [2023 Annual Report - Alert and Cooperation Network](#)

ЕВРОПЫН ХОЛБООНЫ СЭРЭМЖЛҮҮЛЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ СҮЛЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТАЙЛАН

Өмнөх үг



Европын Холбооны Хүнсний аюулгүй байдлын
байгууллагын ерөнхий захирал хатагтай
Sandra Gallina

Өнгөрсөн жил хүнсний аюулгүй байдлын асуудал Европт олон сорилтуудтай тулгарсан, мөн их чухал үйл явдлууд өрнөлөө.

Бид Сэрэмжлүүлэг ба Хамтын Ажиллагааны Сүлжээний (ACN) тайлангаа танилцуулж байхад сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдсон эдгээр өөрчлөлтүүдийг эргэцүүлэн бодох цаг болжээ. Энэхүү тайланд ACN-ийн 2023 оны үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй тоймыг багтаасан болно. Тус тайланд хэт их мэдээлэл өгөхгүйгээр хүнсний бүтээгдэхүүний сэрэмжлүүлэг нэмэгдэж байгааг онцолсон бөгөөд энэ нь ЕХ-ны хяналтын байгууллагуудын хичээл зүтгэл, сонор сэрэмж мөн манай сүлжээнүүдийн хэрхэн хариу арга хэмжээ авч байгаа талаарх мэдээллийг онцлон багтаасан гэж үзэж байна.

Европын холбооны сэрэмжлүүлэх ба хамтын ажиллагааны цахим сүлжээний хүрээ болон нөлөөлөл ЕХ-ны гишүүн орнууд болон түншүүдийн хүрээнд улам илүү өргөжин тэлж байгаад бид баяртай байна. Европын холбоонд хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, мэдээллийг солилцох зорилготой дөрвөн цахим сүлжээ байдаг, Үүнд:

- **Хүнс, гэжээлийн яаралтай сэрэмжлүүлэх систем** (Rapid Alert System for Food and Feed)
- **Удирдлагын тусламж ба хамтын ажиллагаа** (Administrative Assistance and Cooperation)
- **Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний хуурамч бүтээгдэхүүн** (Agri Food Fraud Network)-шинээр нэмэгдэж орсон
- **Ургамлын эрүүл мэндийн сүлжээ** (Plant Health)

Мөн нэг эрүүл мэндийн зарчим Удирдлагын тусламж ба хамтын ажиллагаа (ACN)-ны хүрээнд хэрэгжиж чадсаныг харж байна. Хуурамч хүнсний асуудал энэхүү тайлангийн гол хэсэг юм. Бид хуурамч хүнс, хүнсний луйварыг илрүүлж урьдчилан сэргийлэх талаар хэзээ ч амарч болохгүй. Манай хүнсний хангамж, аюулгүй байдлын системд заналхийлж буй энэхүү өсөн нэмэгдэж буй асуудлыг шийдвэрлэнэ хэмээн иргэд бидэнд найдаж байна. Зөвшөөрөлгүй хүнсний нэмэлт бодис хэрэглэхээс эхлээд бүтээгдэхүүний шошгоны мэдээлэл хангалттай байж чадаагүй байх хүртэлх мэдээллүүд зэрэг ЕХ-ны орнуудад гарч буй олон төрлийн хүнсний аюулгүй байдлын зөрчил, хуурамч бүтээгдэхүүний талаарх олон талыг хамарсан судалгааны тайлан юм. Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний луйвартай тэмцэх бидний хамтын хүчин чармайлтад оролцогч бүх талуудад хэрэгтэй үнэ цэнэтэй мэдээллийн эх сурвалж болж чадна гэдэгт би маш их найдаж байна.

Европын комисс энэ асуудлаар илүү их сонор сэрэмжтэй хэвээр байсаар байх бөгөөд ялангуяа орчин үеийн мэдээллийн технологийн хэрэгсэл, хиймэл оюун ухаанаар дамжуулан улам их хүчин чармайлтыг гаргах болно. Үүний үр дүнд Удирдлагын тусламж, хамтын ажиллагааны сүлжээний (ACN) ололт амжилтыг цоо шинэ түвшинд гаргана гэдэгт бид итгэдэг. Би ойрын ирээдүйд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж өмнө нь гаргасан ахиц дэвшил дээр тулгуурлан ирээдүйд тулгарах сорилт бэрхшээлүүдийг шийдвэрлэхийг тэсэн ядан хүлээж байна.

Баярлалаа

2023 оны хураангуй тайлан

Сэрэмжлүүлэх ба хамтын ажиллагааны сүлжээ (ACN) нь хөдөө аж ахуйн гинжин хэлхээний албан ёсны хяналтын асуудлаар гишүүн орнуудын хооронд удирдлагын мэдээлэл солилцон хамтын ажиллагааг зохицуулдаг.

2023 оны жилийн тайланд ACN-ийн хүрээнд iRASFF цахим системээр дамжуулан солилцсон мэдээллүүдийн тойм, дүн шинжилгээг доорх системүүдээр дамжуулан эмхэтгэн багтаасан.

- **Хүнс, тэжээлийн яаралтай сэрэмжлүүлэх систем** (Rapid Alert System for Food and Feed)
- **Удирдлагын тусламж ба хамтын ажиллагаа** (Administrative Assistance and Cooperation)
- **Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний хуурамч бүтээгдэхүүн** (Agri Food Fraud Network)-шинээр нэмэгдэж орсон
- **Ургамлын эрүүл мэндийн сүлжээ** (Plant Health) – эдгээр хэрэгслэлүүд нь өмнө дурьдсан үр дүнд хүрэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Энэхүү тайланд гишүүдийн сэрэмжлүүлэг ба хамтын ажиллагааны сүлжээ ашиглалт улам өсч Европын гишүүн бус орнууд хамтран ажиллах, мэдээлэл солилцох ажилд илүү их оролцож байгааг харуулж байна. 2023 он бол Ургамлын эрүүл мэндийн сүлжээ үйл ажиллагаагаа явуулсан анхны жил байсан бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайланд оруулав. Европын комисс ACN-ийн менежерийн хувьд ACN-ийн гишүүдэд үргэлжлүүлэн туслан мэдээлэл солилцох ажлыг дэмжихэд дэмжлэг үзүүлсээр байна.


1. Сэрэмжлүүлэг ба хамтын ажиллагааны сүлжээ IRASFF цахим систем

Сэрэмжлүүлэг ба хамтын ажиллагааны сүлжээ IRASFF цахим систем нь ACN-ийн гишүүдийн хооронд мэдээлэл солилцох боломжийг олгодог. Энэхүү сүлжээг Европын комисс (EC) удирддаг бөгөөд албан ёсны хяналтын мэдээллийн менежментийн систем (IMSOC Regulation)-ийн тухай (EU) 2019/1715 дүрмээр батлагдсан **Хүнс, тэжээлийн яаралтай сэрэмжлүүлэх систем** (Rapid Alert System for Food and Feed), **Удирдлагын тусламж ба хамтын ажиллагаа** (Administrative Assistance and Cooperation), **Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний хуурамч бүтээгдэхүүн** (Agri Food Fraud Network), шинээр нэмэгдэж орсон **Ургамлын эрүүл мэндийн сүлжээ** (Plant Health) –гэсэн дөрвөн сүлжээнээс бүрддэг. ACN-ийн сүлжээнүүд нь гишүүдийнх нь эрх бүхий албан тушаалтнууд болон ЕХ-ны гишүүн бус томоохон албан тушаалтнуудын хооронд шуурхай харилцаа холбоо тогтоож хамтран ажиллахад хялбар болгодог. ЕХ нь энэхүү цахим системийг хариуцсан менежерийн хувьд ACN-ийн гишүүдэд мэдээллийн солилцоог улам нэмэгдүүлэх, дэмжихэд шаардлагатай тусламж болон шинжээчдээр хангахад дэмжлэг үзүүлдэг.

RASFF буюу **Хүнс, тэжээлийн яаралтай сэрэмжлүүлэх систем** нь хоол хүнс, тэжээлтэй холбоотой хүний эрүүл мэндэд шууд болон шууд бус эрсдлүүд, хүн, амьтан, хүрээлэн буй орчин, амьтны тэжээлтэй холбоотой эрсдлүүдийн талаарх мэдээлэл солилцох боломжийг олгодог. Дээрх мэдээллийн солилцоо нь RASFF-ийн сайт дээр мэдэгдэл гаргах байдлаар явагддаг. Удирдлагын туслалцаа болон хамтын ажиллагаа, ААС сүлжээний хувьд EC No 178/2002

болон ЕХ-ны дүрэм (ЕС) 2017/625-д заасан эрсдлээс бусад, амьтан, ургамлын эрүүл мэнд, амьтны эрүүл аюулгүй байдалд учруулах ноцтой бус эрсдлүүдийн зөрчлүүдийн талаарх мэдээллүүдийг солилцох, мөшгих, арга хэмжээ авах боломжийг эрх бүхий албан тушаалтнуудад олгодог. Эдгээр үйлдлүүдийг мөн (ААС)-ийн системд үл тохирол гарсан тухай мэдэгдлээр харуулж явдаг. Хуурамч эсвэл орлуулсан хүнсний бүтээгдэхүүн илэрсэн тохиолдолд Хуурамч ХАА-н хүнсний бүтээгдэхүүний сүлжээнд мэдээлдэг. Хэрэглэгчдийг хууран мэхэлж эдийн засгийн болон санхүүгийн ашиг олох зорилгоор бизнес, хувь хүмүүс санаатайгаар үйлдэл хийсэн хэмээн сэжиглэсэн зөрчлүүд энд хамаарна. Эдгээр тохиолдлуудад зөвхөн хуурамч бүтээгдэхүүн хариуцсан албан тушаалтнуудад зориулсан мэдээллийг хаалттай, өндөр нууцлалтайгаар дамжуулах замаар явагддаг.

Зураг 1. Анхааруулан сэрэмжлүүлэх болон хамтын ажиллагааны сүлжээ



2. Сэрэмжлүүлэг ба хамтын ажиллагааны сүлжээний хүрээнд хэрэгжүүлдэг гол үйл ажиллагаа

Дээрх дөрвөн сүлжээний хэрэглээ бүгд 2023 онд 2022 оныхтой харьцуулахад ихээхэн өссөн бөгөөд тавигдаж буй мэдэгдлийн тоогоор RASFF (4695) 8%, ААС (3166) 24%, FF (758) 26% тус тус өссөн байна. Ургамлын эрүүл ахуйн системд 128 мэдэгдлийг бүртгэсэн. Анхны мэдэгдлээс гадна гишүүн орнуудын эрх мэдэл бүхий байгууллагууд болон ЕХ-ны зүгээс нэмэлт мэдээллүүд (үүнд мэдэгдлийн дараа авсан арга хэмжээ, үр дүн, бусад улс орнуудад түгээх, баримт бичгүүдийг оруулах гэх мэт) оруулж болно.



Өмнөх жилүүдийн нэгэн адил RASFF-ийн мэдэгдлийн гуравны нэгээс илүү нь хилээс буцаагдсан тухай мэдээлэл байна. Гарал үүслээр нь авч үзвэл ихэвчлэн Турк, Египет, Энэтхэгээс ирсэн жимс, хүнсний ногоонд пестицидийн үлдэгдлийн зөрчилтэй байна. АСН-д хамгийн их мэдэгдлийг оруулж буй орнууд Герман, Нидерланд, Бельги юм. ЕХ-ны зүгээс системд оруулж буй бүх мэдэгдлийг хянаж эдгээр мэдээллийг дамжуулах үйл явц зөв сүлжээгээр дамжуулж буй эсэхийг хянаж үнэлнэ. 2023 онд ААС-д бүртгэгдсэн 57 мэдэгдлийн зэрэглэлийг нэмэгдүүлж RASFF-д шилжүүлсэн байна. Мөн RASFF-д бүртгэгдсэн 105 мэдэгдлийг хүчингүй болгосон байна. Эрүүл мэндийн аюул, эрсдэл илэрсэн үед ААС- сүлжээнд бүртгэгдсэн мэдэгдлийг RASFF-ийн сүлжээ рүү дамжуулан бүртгэдэг. Үүнтэй адилаар, эрүүл мэндэд аюул, эрсдэл учруулахгүй гэж үзсэн тохиолдолд ЕХ-оос RASFF-д бүртгэхээс татгалзаж ААС сүлжээнд үргэлжлүүлэн бүртгэж болно.

Энэхүү хүнсний аюулгүй байдлын бүртгэлийн системтэй холбоотой олон асуудлаар ажлын хэсэг, бүлгийн хурлыг тогтмол зохион байгуулдаг. Түүнээс гадна, ЕХ нь RASFF болон AAC-д бүртгэгдсэн мэдэгдлүүдэд хуурамч болон луйврын шинжтэй зөрчлүүд байж болзошгүй байх талаас нь хянаж дүгнэж байдаг. 2023 онд 1075 AAC болон 1625 RASFF-ийн мэдэгдлийг луйвар байж болзошгүй хэмээн онцолж гишүүн орнуудыг луйварын талаар нарийвчилсан судалгаа хийхийг уриалсан байна.

3. Сэрэмжлүүлэг ба хамтын ажиллагааны сүлжээг тоон мэдээдэллээр харуулвал


3.1 Хүнс, тэжээлийн яаралтай сэрэмжлүүлгийн систем 2023 онд нийт 4695 RASFF-ийн мэдэгдэл гаргаснаас 4199 нь хүнс, 303 нь тэжээл, 193 нь хүнсний сав баглаа боодолтой холбоотой мэдэгдлүүд байсан. Энэ нь системээр дамжсан мэдэгдлүүдийн хамгийн өндөр тоо байсан бөгөөд 2022 онтой харьцуулахад 8%-иар өссөн. Анхааруулсан сэрэмжлүүлсэн мэдэгдлүүд 2022 оноос 9%, араас нь хяналт тавих мэдэгдэл 23%, анхаарал хандуулах мэдээлэл 6%, хил дээрээс буцаасан мэдэгдэл 2% тус тус өссөн байна. Мэдээллийн мэдэгдлүүдийн тоо хэвээр байсан.

Зураг 2: Хүнс, тэжээлийн яаралтай сэрэмжлүүлгийн систем RASFF-ийн мэдэгдлийг төрлөөр нь ангилбал



Зах зээлд илрүүлсэн зөрчлүүдийн хамгийн их мэдэгдэл гаргасан тохиолдлууд нь албан ёсны хяналт шалгалтын үед (1443), дараа нь компанийн өөрсдийн хяналт шалгалтын үед (983), хэрэглэгчийн гомдол (250) болон тандан судалгаа хяналтын хөтөлбөр / хяналтын дээжний шинжилгээний үед (83) илэрсэн зөрчлийн мэдэгдлүүд байв. (Зураг 3)

Зураг 3. Мэдэгдлийг гаргасан үндэслэлээр нь Хүнс, тэжээлийн яаралтай сэрэмжлүүлгийн систем RASFF-ийн мэдэгдлүүдийг ангилбал:



Өмнөх гурван жилтэй адилхан Герман улс хамгийн их (592 мэдэгдэл) мэдэгдэл гаргасан орон хэвээр байгаа бол түүний дараа Нидерланд (589), Франц (421), Итали (411) оржээ. Тодруулбал, 2023 онд Франц улс 2022 оныхтой харьцуулахад энэ чиглэлд үйл ажиллагаагаа 50%-иар нэмэгдүүлжээ. 2023 онд хийсэн судалгааны дүнгээс харахад мэдэгдлийн дараах арга хэмжээ авсан гишүүн орнуудад Герман, Итали (1954, 1106), дараа нь Нидерланд (1051), Польш (998) орж байна. Барааны гарал үүслийн хувьд мэдэгдэлд хамгийн их дурьдагдсан орнуудыг Зураг 4-т үзүүлж байна. 2022 онтой холбогдуулан RASFF-ийн гишүүн орнуудад Польш (304 мэдэгдэл), Нидерланд (289), Франц (269) багтсан байна. Гарал үүслийн хувьд хамгийн их давтагддаг гишүүн бус орнуудад Турк (408 мэдэгдэл), Хятад (333), Энэтхэг (303) тус тус орж байна.

Зураг 4: Хүнс, тэжээлийн яаралтай сэрэмжлүүлгийн систем дэх RASFF-ийн мэдэгдлийг бүтээгдэхүүний гарал үүслээр нь харуулбал:



3.1.1. Аюулын ангилал


Хүснэгт 1-д 2023 онд хамгийн их давтагддаг RASFF-ийн мэдэгдлүүдийг аюулын ангилал, бүтээгдэхүүний ангилал, гарал үүслийг улсаар нь нэгтгэн харуулж байна. Үүнд бүх төрлийн бүтээгдэхүүн (хоол хүнс, тэжээл, хүнсний сав баглаа боодлын материал), тэдгээрийн гарал үүсэл, хил болон зах зээлд хийсэн хяналтын төрлүүд зэрэг мэдээллүүдээр нь ангилан харуулж байна.

Хүснэгт 1. Европын холбооны Хоол хүнс, тэжээлийн яаралтай сэрэмжлүүлэх системд хамгийн их бүртгэгдсэн 10 аюултай зөрчлийн мэдэгдлүүд

Аюул/зөрчил	Бүтээгдэхүүний зөрчил	Гарал үүсэл	Мэдэгдлүүд
Пестицидийн үлдэгдэл	Жимс, хүнсний ногоо	Турк	168
Салмонелла	Шувуу, шувууны гаралтай бүтээгдэхүүн	Польш	153
Шилжилт	Хүнсний сав баглаа боодол	Хятад	92
Афлотоксин	Самар, самарны бүтээгдэхүүн, үр	АНУ	85
Пестицидийн үлдэгдэл	Жимс, хүнсний ногоо	Египет	84
Пестицидийн үлдэгдэл	Халуун ногоо, хатаасан ургамал	Энэтхэг	51
Пестицидийн үлдэгдэл	Үр тариа, талх талхан бүтээгдэхүүн	Энэтхэг	48
Салмонелла	Самар, самарны бүтээгдэхүүн, үр	Нигер	38
Виабрио	Хавч болон хавчны гаралтай бүтээгдэхүүнд	Эквадор	36
Пестицидийн үлдэгдэл	Үр тариа, талхан бүтээгдэхүүн	Пакистан	34

Зураг 5-д хүснэгтэд илрүүлсэн бүх аюул, зөрчлийг ангиллаар нь харуулж байна (тэжээл болон хүнсний сав баглаа боодлыг оруулаагүй). Эдгээр аюулын ангиллууд нь ЕХ-ийн дотоод мэдээллийн сан дахь аюулын нэр заагдсан өгөгдлөөс шалтгаалан RASFF-ийн мэдэгдлийн төрлүүд рүү шууд автоматаар ордог гэдгийг тодруулж хэлэх хэрэгтэй. Пестицидийн үлдэгдэл, өвчин үүсгэгч нян болон микотоксинууд нь хамгийн их бүртгэгдсэн аюулын ангилал байсан бөгөөд энэ талаар тайлангийн дараагийн хэсэгт танилцуулах болно. Дууриалгасан/хуурамч гэдэг ангилалд зөвхөн тодорхой төрлийн аюул, зөрчлүүдийг (эрүүл мэндийн гэрчилгээ, шинжилгээний тайлан буруу эсвэл байхгүй, хууль бусаар импортлох оролдлого гэхчлэн) оруулж байна. Тиймээс луйварын бүрэлдэхүүн хэсгүүд илрүүлсэн бүх мэдэгдлийг хамруулдаггүй (энэ талаар 3.3 дахь хэсэгт авч үзнэ)

Зураг 5: Европын холбооны Хоол хүнс, тэжээлийн яаралтай сэрэмжлүүлэх системд 2021-2023 онд бүртгэгдэж мэдээлэгдсэн хүнсний аюулгүй байдлын зөрчлүүдийг ангилж үзэхэд:



- Пестицидийн үлдэгдэл
- Өвчин үүсгэгч бичил организмын бохирдол
- Мөөгөнцрийн бохирдол
- Хуурамч хүнс
- Тусгай хүнс
- Харшил үүсгэгч
- Найрлага
- Гадны биетийн бохирдол
- Хүнсний нэмэлт


3.1.2. Хоол хүнсн дэхь пестицидийн үлдэгдэл

Сүүлийн хоёр жилийн мэдээлснээр 2021 онтой харьцуулахад 24%, 2022 онтой харьцуулахад 5.5%-иар буурсан хэдий ч 2023 онд пестицидийн үлдэгдэл RASFF-д (936 мэдэгдэл) хамгийн их мэдээлэгдсэн хүнсний аюулын ангилалд багтжээ. Хамгийн их бүртгэгдсэн бүтээгдэхүүний ангилалд жимс, хүнсний ногоо (560 мэдэгдэл) багтсанаас хилийн хяналт шалгалтаар 372 тохиолдол, зах зээлд 188 тохиолдол илэрсэн байна. RASFF-д пестицидийн үлдэгдэл Туркийн жимс, хүнсний ногоо (168 мэдэгдэл)-д бүртгэгдсэн бөгөөд 2022 оны тайланд Болгар (112), Герман (70) улсуудаас хамгийн их мэдэгдлийг үүсгэжээ.

Зураг 6-д үзүүлснээр хамгийн түгээмэл пестицид нь chlorpyrifos (299), acetamiprid (75), ethylene oxide and 2-chloroethanol (67) тус тус байна. 2022 онтой харьцуулахад chlorpyrifos methyl, ethylene oxide and 2-chloroethanol-ын үлдэгдлийн тоо 60 орчим хувиар буурсан бол харин chlorpyrifos-ын тохиолдол 19.1%-иар нэмэгджээ.




Зураг 6. RASFF-д хамгийн их мэдээлэгдсэн эхний 10 пестицид



3.1.3. Өвчин үүсгэгч микроорганизмүүд

2023 онд эмгэг төрүүлэгч нянгууд хүнсний бүтээгдэхүүнд хамгийн түгээмэл тохиолдож буй хоёр дахь аюул буюу бохирдлын ангилалд (856 мэдэгдэл) орсон байна. Энэ төрлийн бохирдлын хамгийн их бохирдсон хүнсний бүтээгдэхүүнд шувууны мах, шувууны махан бүтээгдэхүүн (316), самар, самрын төрлийн бүтээгдэхүүн, үр (93) орсон байна.

Зураг 7: Хоол хүнсн дэхь өвчин үүсгэгч бичил биетнүүдийн RASFF мэдэгдэл



3.1.4. Микотоксин

Микотоксины бохирдлын зөрчлүүд 401 удаа мэдээлэгдсэн гэдгээрээ гурав дахь хамгийн их тохиолддог зөрчилд орж байгаа бөгөөд 2022 онтой харьцуулахад 17% хувиар багассан. Мэдэгдлүүдээс харахад афлатоксины илүүлэлт (331) самар болон самарны төрлийн бүтээгдэхүүнд, үрэнд (226) хамгийн их илэрсэн байна. Гарал үүслийн хувьд АНУ-аас ирсэн тохиолдлууд хамгийн ихээр бүртгэгджээ.



3.1.5. Хоол хүнснээс үүдэлтэй өвчлөл

RASFF-д 48 хүнсээр дамжсан халдварт өвчний дэгдэлтийн талаарх мэдэгдэл ирсэн байна. Үүнээс 17 тохиолдол нь норовирус (магадлалтай), 11 тохиолдолд сальмонелла, 5 тохиолдолд *Listeria monocytogenes*, 2 тохиолдолд гистамины хордлого, 2 тохиолдлоор гэдэсний савханцар илэрчээ. Эдгээр 48 мэдэгдлийн 18 нь олон улсыг хамарсан хүнсний гаралтай дэгдэлттэй холбоотой байв. Ийм тохиолдолд Европын Холбооны Хүнсний Аюулгүй Байдлын Газар (EFSA) болон Европын өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах төв (ECDC) нь ЕХ-той зөвлөлдсөний дараа хамтын ажиллагааг эхлүүлэхээр шийдвэрлэж болно. Энэ үйл ажиллагааг ЕХ-ны зүгээс мөн дэмжин ажилладаг. EFSA-ECDC хамтран олон нийтэд нээлттэй Шуурхай Дэгдэлтийн Үнэлгээ (ROA) эсвэл олон нийтийн бус хамтарсан мэдэгдлийн хураангуй (JNS) мэдэгдлүүдийг гаргана. Энэ хүрээндээ дэгдэлтэнд өртсөн орнуудтай уялдаа холбоог хөгжүүлж ажилладаг. ROA буюу Шуурхай Дэгдэлтийн Үнэлгээ нь нийгмийн эрүүл мэндийн байдлын ерөнхий тоймыг гаргаж, дэгдэлтийг хариуцах бохирдсон хүнсний тээврийн хэрэгслийг тодорхойлж өгдөг. Мөн дэгдэлтийн гарал үүсэл, бохирдсон бүтээгдэхүүний тархалтыг тодорхойлоход чухал үүрэгтэй дэгдэлт гарахын өмнө болон дараах мөрдөх үр дүнг нэгтгэдэг. Өвчний дэгдэлтэнд өртсөн сүлжээний гишүүд RASFF-ийн мэдэгдлүүдийг ашиглан хүнсний талаар явуулж буй судалгаагаа мэдээлдэг. Эдгээр ажлууд дууссаны дараа EFSA болон ECDC нь ROA-ийн нэргүй хувилбарыг вэбсайтаа нийтэлдэг.

3.1.6. Бусад аюулын ангилал

Тусгайлсан, буюу шинэ хүнсний бүтээгдэхүүнүүд нь аюултай байдлаараа тавдугаарт ангилагдаж бүртгэгдэж байгаа бөгөөд эдгээрээс cannabinoids хамгийн их бүртгэгдсэн байна. Энэ талаар дэлгэрэнгүй дараагийн хэсэгт авч үзэх болно (3.5.1). Үүний дараагаар харшил үүсгэгч (217 мэдэгдэл)-тэй холбоотой мэдэгдлүүд ихэвчлэн бэлтгэсэн хоол, хөнгөн зууш зэрэг (41 мэдэгдэл) бүтээгдэхүүнд бүртгэгдсэн байна. Сүүтэй холбоотой харшил үүсгэгчид хамгийн их бүртгэгдсэн болохыг дурдах нь зүйтэй (39).

Нэмж дурьдахад, бүтээгдэхүүний найрлагатай холбоотой тохиолдлууд мөн олон давтагддаг (231 мэдэгдэл) бөгөөд голчлон хоолны дэглэмийн бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт тэжээл, баяжуулсан хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой (106) байна.

3.1.7. Тэжээл

2023 онд RASFF-ийн 303 мэдэгдлийг тэжээл дээр бүртгэсэн. Асуудал нь зах зээл дээрх албан ёсны хяналт (94 мэдэгдэл) болон компанийн өөрийн шалгалт (99) үед голчлон илэрсэн. Салмонелла нь хамгийн их бүртгэгдсэн аюул байсан (111) бол бусад байнга бүртгэгддэг мэдээлэлд бичил биетний бохирдуулагчид, тэжээлийн материалд хөгц мөөгөнцөр байна. Польш улс Украины наранцэцгийн тэжээлийн талаар (20), Португал улс Анголын улаан буудайн хивэгний тухай (13 мэдэгдэл) удаа дараа мэдэгдэл гаргасан. Enterobacteriaceae-г ихэвчлэн илрүүлсэн (15) нохой зажлах бүтээгдэхүүний бохирдол 8 тохиолдол бүртгэгдсэн. 2022 оны байдлаар 17 бүтээгдэхүүний орц найрлагатай холбоотой мэдэгдэл ирсэн бөгөөд хамгийн түгээмэл аюул нь бусад ургамалд ragweed (*Ambrosia* spp.) үрийн (11) бохирдол их хэмжээтэй байсан. 23 мэдэгдэл нь микотоксинтай холбоотой бөгөөд голчлон афлатоксинтай мөн холбоотой байв (21). Пестицидийн үлдэгдлийн 19 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд голчлон хлормекват (4) ба хлорпирифос (4)-тэй холбоотой байв. Тэжээлд агуулагдах металлын үлдэгдэл 16 удаа бүртгэгдсэнээс хар тугалгатай холбоотой 9 мэдэгдэл, тодруулбал нохойн тэжээлд 4 удаа илэрсэн байна.

3.1.8. Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын материал

Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын материалын талаар 193 мэдэгдэл ирсний 36% нь анхдагч үнэрт амин нэгдлүүд (40 мэдэгдэл), формальдегид (16), хар тугалга (15) зэрэг химийн нэгдлүүдийн бүтээгдэхүүн рүү нэвчих шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байна. Ихэнх бүтээгдэхүүн (124) Хятадаас гаралтай. Хамгийн сүүлд Франц (37), Итали (31), Ирланд (21) зэрэг улсууд эдгээр мэдэгдлүүдийг гаргасан байна. Хүснэгт 2-т хамгийн их бүртгэгдэж

мэдээлэгдсэн шилжилт хийгдсэн химийн нэгдлүүдийг, ямар төрлийн хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын материал дээр илэрч байгааг харуулав.

Хүснэгт 2. Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын материал ба шилжилт хамгийн ихээр хийгдэж буй бодисуудын мэдээлэл

Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын материал	Шилжилт хийж буй химийн нэгдлүүд
Нейлон	Анхдагч цагираган аминууд
Меламин	Формальдегид, меламин
Силикон	Ууршилттай органик бүтцүүд
Савны таглаа, цаасан картон хайрцаг	Хар тугалга, хуванцар
Метал	Хар тугалга, хром

3.1.9. Эрдэнэ шишийн гурил буюу тортилла дахь Capsaicinoid

"Халуун чипсний сорилт" хэмээн нэрлэгдэх маш халуун ногоотой чинжүү болон перецний ханданд амталсан чипсний хэрэглээ 2023 онд их алдаршсан. Техас мужид төвтэй нэгэн компани "One Chip Challenge" буюу Нэг чипсний сорилтыг санаачилсан бөгөөд энэ нь тус тусад нь савлаж боосон халуун ногоогоор амталсан эрдэнэшишийн чипсийг иднэ. Хүмүүс ийм чипсийг идэхийг оролдож байгаагаар бичлэг болгон олон нийтийн сүлжээгээр их цацаж ингэснээр олон улсад танигдаж их газар авсан байна. Энэ бүтээгдэхүүнийг хэрэглэснээр дотор муухайрах, бөөлжих, цусны даралт ихсэх, нүд шатаах, салст бүрхэвчийг цочроох зэрэг гаж нөлөө илэрч болзошгүй юм байна. Эдгээр үр нөлөөг үл харгалзан бүтээгдэхүүн нь хоол хүнсэнд хэрэглэхийг зөвшөөрсөн найрлагатай тул хууль бус гэж тооцогдсонгүй. 2023 оны есдүгээр сард АНУ-д хүүхэд нас барсан нь нэг ийм төрлийн тортилла чипс хэрэглэсэнтэй холбоотой байв. Үйлдвэрлэгийн зүгээс зөвхөн насанд хүрэгчид хэрэглэж болно гэдгийг шошгон дээр тодорхой бичсэн байдаг гэдгийг тус компанийн хэвлэлийн мэдээлэлд дурьджээ. Аравдугаар сард Швейцарь улс, Чехийн нэгэн компанийн үйлдвэрлэсэн халуун ногоотой чипс тортиллагаас 9300 мг/кг дахь capsaicinoid илэрсэнтэй холбоотой RASFF-ийн мэдэгдэл гаргасан. Швейцарийн эрсдлийн үнэлгээгээр 6000 мг/кг capsaicinoid нь 60 кг жинтэй эрүүл насанд хүрсэн хүний хэрэглэх хамгийн дээд хэмжээ юм. Хоёр долоо хоногийн дотор Герман улс төрөл бүрийн дээжинд 4000-15000 мг/кг capsaicinoid илэрсэн шинжилгээний тайланг мэдээлсэн. Capsaicinoid-ын агууламжийн ийм мэдэгдэхүйц ялгаатай байгаа нь уг бүтээгдэхүүнийг нэг дор хэрэглэхэд эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй байдалд хүргэдэг байна. Чехийн эрх бүхий байгууллагууд үйлдвэрлэгчээс хэрэглэгчдэд бүтээгдэхүүний хэт халуун ногоотой байдлын талаар хангалттай мэдээлэл өгдөг гэж мэдэгдсэн ба савласан нь бүтээгдэхүүн тус бүрт чипсийг идэх үед хэрэглэх бээлийтэй байдаг гэдгийг онцлон тэмдэглэв. Гэсэн хэдий ч Германы албаны хүмүүсийн зүгээс Англи хэл дээрх анхааруулга хангалтгүй байгааг онцлон тэмдэглэж байна. Италийн монополийн эсрэг байгууллагын мэдээлснээр бүтээгдэхүүний сонирхол татахуйц, борлуулалтыг нэмэгдүүлэхэд ашигладаг тусгай маркетинг нь ялангуяа залуу хэрэглэгчид анхааруулгыг үл тоомсорлоход хүргэдэг гэдгийг дурьдаж байна. 11, 12-р саруудад уг бүтээгдэхүүнийг Европын бөөний худалдаагаар ЕХ-ны 23 улс болон ЕХ-ны гишүүн бус гурван оронд түгээж худалдаалах, мөн онлайн худалдаагаар зарах гэж байгааг олж тогтоожээ. 11-р сарын 27-нд Бүгд Найрамдах Чех улс уг бүтээгдэхүүнийг зах зээлд гаргааа зогсоосон тухай мэдээлсэн. Түүний дараа capsaicinoid-ийн агууламжийг багасгасан "Hot Chip Challenge 2,8g New Recipe" нэрээр шинэ савлагаа бүхий бүтээгдэхүүнийг худалдаанд гаргасан байна.

Тайлангийн үргэлжлэлийг дараагийн мэдээллээр орчуулан хүргэх болно.

Инно Хими Лаб ХХК – ийн танилцуулга:


Үйлчилгээний нэр төрөл:

- Хүнс, хүрээлэн буй орчны шинжилгээний лабораторийн шинжилгээ
- Химийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис, урвалжийн худалдаа
- Химийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ
- Химич, химийн мэргэжилтний сургалт, зөвлөгөө

Бүтээгдэхүүний нэр төрөл:

- Тоног төхөөрөмж
- Багаж хэрэгсэл
- Урвалж, уусмал
- Стандарт бодис, оношлуур
- Химийн бодис
- Шил сав, дагалдах хэрэгсэл

Хэрэглэгчидийнхээ цаг завьг хэмнэх, тасралтгүй ажиллагааг дэмжих үүднээс www.innochem.mn онлайн худалдааны сайтыг нэвтрүүлээд байна.



Инно лаборатори

- Химийн лабораторийн мэргэжилтнүүдэд өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах орчин бүрдүүлэх, чадамжийг сайжруулах
- Хүнсний болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахад лабораторийн шинжилгээг олон улсын стандартын дагуу нэвтрүүлж хувь нэмрээ оруулах

Шинжилгээний хүрээ:

- Пестицидийн үлдэгдлийн шинжилгээ
- Усанд болон тосонд уусдаг витаминь шинжилгээ
- Хүрээлэн буй орчны бохирдлын шинжилгээ